


Шүүхийн ерөнхий зөвлөлийн  
2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн  
17 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



## НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ

Нэг. Ерөнхий зүйл	
1.1	Шүүхийн нэр
1.2	Мэдүүлэг гаргагчийн овог, нэр
1.3	Хянан шийдвэрлэж /оролцож/ буй хэрэг, маргаан

Хоёр. Нөлөөллийн арга, хэрэгсэл	
2.1	Шууд /хэн, хэзээ, хаана уулзахыг ямар арга, хэрэгслийг ашиглан санал болгосон/ ..... .....
2.2	Шууд бус /дамжуулсан этгээдийн тухай, харилцаа холбооны болон хэвлэл мэдээллийн ямар хэрэгслийг ашиглан нөлөөлсөн/ ..... .....

Гурав. Нөлөөллийн хэлбэр	
3.1	Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөх, өгөхийг завдах
3.2	Албан тушаал санал болгох, /өөрт болон гэр бүлийн гишүүдэд/
3.3	Дарамт шахалт үзүүлэх /дээд албан тушаалын эрх бүхий этгээдээс/
3.4	Дарамтлах, заналхийлэх, сүрдүүлэх
3.5	Гүтгэх, доромжлох
3.6	Шүүгчийн бие, орон байр, унааны аюулгүй байдалд халдах
3.7	Шийдвэрийг урьдчилан хэлэлцэхийг санал болгох
3.8	Шийдвэрийн талаар урьдчилан зааварчилгаа өгөх
3.9	Нөхцөл байдлыг тайлбарлах
3.10	Бусад хэрэг, маргааны шийдвэрийг жишиг болгохыг санал болгох
3.11	Бусад

Дөрөв. Тусгай мэдээлэл	
4.1	Нөлөөлөх оролдлого давтагдсан байдал


4.2	Гэрчлэх этгээдийн тухай мэдээлэл	
4.3	Нөлөөлөх оролдлогыг баримтжуулсан материал байгаа эсэх	
<b>Тав. Хавсаргасан баримт</b>		
5.1	Нөлөөлөх оролдлогыг баримтжуулсан материал /гэрчлэх этгээдээс авсан тайлбар, тодруулга, албан бичиг, захидал, дуу, дүрс бичлэг г.м/	

Мэдүүлэг хөтлөгч \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

\_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

--000--

Шүүхийн ерөнхий зөвлөлийн  
2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн  
17 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



ШҮҮХ

/Шүүхийн нэр/

он сар

/баримт үйлдсэн газрын нэр/

## НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛСАН БАРИМТ

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Нөлөөллийн мэдүүлэг гэж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэг, маргааны шийдвэрлэлтэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан, эрүү, иргэн, захиргааны хэргийн материалд хавсаргагдах баримт бичгийг” ойлгоно гэж заасан.

Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэг маргааны шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлсөн бүх үйлдэлд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т дахь хэсэгт заасны дагуу “**нөлөөллийн мэдүүлэг**” хөтөлнө.

Нөлөөллийн мэдүүлэгт дурдсан мэдээллийг шалгуулах, зохих хариуцлага ногдуулах асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлж, энэ тухай олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүрт нь мэдээлнэ.

Шүүгчийн хараат бус байдалд халдсан этгээдэд дараах хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

### Нэг. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль

38.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

38.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

38.3. Энэ хуулийн 38.2-т заасны дагуу хариуцлага хүлээсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсаас албадан гаргаж, дахин ирэх эрхийг нь 10 хүртэл жилээр хасна.

### Хоёр. Эрүүгийн хууль

#### 21.6. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх

*/Энэ зүйлийн гарчигт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт,

мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

2.Энэ гэмт хэргийг дээд шатны албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд дарамт шахалт үзүүлж, давуу байдал бий болгож, бий болгохоор амлаж, ятгаж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -“Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно.

### Гурав. Зөрчлийн тухай хууль

#### 15.4 дүгээр зүйл. Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхийг оролдох

1.Шүүгчийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл шүүх, шүүгчийн аюулгүй байдлын журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх оролдлогыг гаргасан тохиолдолд хүлээлгэх хуульд заасан хариуцлагын тухай мэдээлэлтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн болно.

д/д	Хэргийн ямар оролцогч болох	Эцэг /эх/-ийн овог нэр; нэр	Гарын үсэг	Он сар өдөр
1				
2				
3				

Танилцуулсан мэдүүлэг хөтлөгч, түүний даалгасан этгээд /\_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого ирсэн эсэх: \_\_\_\_\_

Мэдүүлэг хөтлөгч \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

\_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар

/Хувийг хэрэгт/